

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20<sup>24</sup>.... оны 09..... сарын 09..... өдөр

№ R-2024-41

Улаанбаатар хот

Эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын үр дүнг хүлээн зөвшөөрөх тухай

Компанийн тухай хуулийн 73.11 дэх хэсэгт заасны дагуу ХасБанк ХК ("ХасБанк")-ийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТҮЗ")-ийн 2024 оны 9 дүгээр сарын 04-09-ний өдрийн хооронд зохион байгуулсан цахим санал хураалтаар дараах шийдвэрийг гаргав:

## ТЭМДЭГЛЭХ нь:

- ХасБанк нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2024 оны 7 дугаар сарын 25-ны өдрөөс 9 дүгээр сарын 04-ний өдрийн хооронд, ХасБанкны 2024 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг зарлан хуваарилах тухай асуудлыг шийдвэрлүүлэхээр эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулсан болохыг;
- ТҮЗ-ийн 2024 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн R-2024-34 дүгээр тогтоолоор байгуулагдсан Тооллогын комисс нь Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн саналыг хүлээн авч, санал хураалтын дүнг нэгтгэсэн тайланг 2024 оны 9 дүгээр сарын 04-ний өдөр ТҮЗ-д хүргүүлсэн болохыг;
- Тооллогын комисс нь ХасБанкны Дүрэмд заасны дагуу эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд нийт 1,006,819,619 ширхэг хувьцааг буюу нийт гаргасан хувьцааны 95.64%-ийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид оролцсон тул хурлыг хүчин төгөлдөрт тооцсон болохыг;
- Эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын үр дүн дараах байдалтай болохыг тус тус тэмдэглэв:
  - ХасБанкны 2024 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг зарлан хуваарилах тухай асуудлаар хуралд оролцож буй саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 1,006,678,626 ширхэг хувьцаа буюу 99.99% зөвшөөрсөн, 416 ширхэг хувьцаа буюу 0.00% татгалзсан, 140,577 ширхэг хувьцаа буюу 0.01% түдгэлзсэн.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1,006,678,626	99.99%	416	0.00%	140,577	0.01%

ТОГТООХ нь:

1. Эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын үр дүнг Тооллогын комиссын танилцуулсан ёсоор дараах байдлаар хүлээн зөвшөөрсүгэй:
  - i. "ХасБанкны 2024 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай" хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол нь эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.99% буюу 1,006,678,626 ширхэг зөвшөөрсөн саналаар батлагдав.
2. ХасБанкны дүрмийн 8.9 дэх хэсэгт заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргын хувьд хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолд гарын үсэг зурахыг ТУЗ-ийн дарга Санжай Гүптад даалгаж, холбогдох эрхийг олгосугай.
3. Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээ авахыг даалгаж, холбогдох эрхийг олгосугай.
4. Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Мөнхцэлмэгт Компанийн тухай хуульд заасан хугацаанд, холбогдох журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолыг нийтэд мэдээлэхийг үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХАСБАНК

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ